

БНСУ-ын экспортыг дэмжих тогтолцоо, Монгол Улсад хэрэгжүүлж болохуйц туршлага

Дашдаваагийн Мянгар¹

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
myagmar_d@mas.ac.mn

Хураангуй: Экспортын хөгжилд төрийн байгууллагуудын дэмжлэг, шуурхай үйл ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэдэг. Бид эдийн засгаа төрөлжүүлэхийн тулд экспортыг дэмжих төрийн байгууллагын үр ашигтай бүтцийг бүрдүүлэх шаардлагатай. Энэ хүрээнд БНСУ-ын Үйлдвэрлэл худалдаа, нөөцийн яам тэргүүтэй экспортыг дэмжих байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг судаллаа. Үйлдвэрлэл худалдаа, нөөцийн яам нь тус улсын экспортыг дэмжих үйл ажиллагааг төлөвлөн, харьяа агентлагууд, мөн бусад төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлж байна. Олон жилийн хөгжлийн явцад хэвшин тогтсон энэхүү тогтолцоо нь харилцан уялдаатай, нарийн зохион байгуулалттай, өндөр үр ашигтай ажиллаж иржээ.

Түлхүүр үгс: БНСУ, экспорт, аж үйлдвэрлэл, экспортыг дэмжих байгууллага

Оршил

Монгол Улсын эдийн засгийг байгалийн эрдэс баялгийн экспортын хараат байдлаас гаргахын тулд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих нь чухал. Энэ үүднээс манай улсын Засгийн газар 2018 оноос Монгол экспорт, Экспортыг дэмжих төсөл, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөр зэрэг олон төсөл хөтөлбөр санаачлан хэрэгжүүлсэн. Гэвч нийт экспортод эзлэх уул уурхайн бус бараа бүтээгдэхүүний хэмжээ дорвитой нэмэгдэхгүй байна. Энэ нь манай улсын төрийн институтийн (хууль тогтоох, гүйцэтгэх засаглал) үйл ажиллагаа дотоодын нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг дэмжихэд чиглэгдээгүй, экспортыг дэмжих бодлого хөтөлбөр төлөвлөн хэрэгжүүлдэг төрийн байгууллагын үр ашигтай тогтолцоо (засгийн газар тэргүүтэй) бүрдээгүйтэй холбоотой. Нэгдсэн удирдлага төлөвлөлттэй, хянах, дүгнэх механизмтай, бодлого хөтөлбөр хэрэгжүүлэх агентлагууд бүхий экспортыг дэмжих тогтолцоо

бүрдүүлбэл төрийн бодлого хөтөлбөрийн үр өгөөж нэмэгдэж, экспорт төрөлжих боломж нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл экспортын хөгжилд төрийн шуурхай дэмжлэг идэвх санаачилга, үүрэг оролцоо зайлшгүй шаардлагатай болох нь энэ бүхнээс тодорхой харагдаж байна.

Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ)-аас экспортын хөгжилд төрийн институтийн үйл ажиллагааны чанар шууд нөлөөлдгийг судалгаагаар тогтоосон.¹ Дэлхийн аж үйлдвэржсэн улс орнууд юу үйлдвэрлэдгээс үл хамааран төрийн институтийн зүгээс аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэл, худалдааны таатай орчин бүрдүүлж байгаа нийтлэг тал байна. Өөрөөр хэлбэл өндөр хөгжилтэй улс орнуудын төрийн институт нь бүтэц зохион байгуулалтын хувьд ялгаатай байж болох ч чиг үүргийн хувьд бизнес эрхлэгчдэд үйлдвэрлэл болон гадаад худалдаа хийхэд тулгардаг түгээмэл саад бэрхшээлүүдийг хөнгөвчилж, боломж гаргаж өгч байгаагаараа төстэй юм. Энэ өнцгөөс авч үзвэл өндөр хөгжсөн

¹ UNCTAD/DITC/TAB/2005/1



улс орнуудын аж үйлдвэрлэл, экспортын хөгжлийн туршлагаас судлах нь зүйтэй.

Бидний стратегийн түнш БНСУ 2023 онд 632 тэрбум ам. долларын бүтээгдэхүүн экспортолж, дэлхийд 5 дугаарт бичигдсэн нь байгалийн нөөц баялаггүй, газар нутаг багатай уг орны төрийн институтийн үйл ажиллагааны чанарыг илтгэж байна². БНСУ-ын төрийн институт нь бүхэлдээ аж үйлдвэр, экспортыг дэмжихээр зохион байгуулагджээ. Ялангуяа

гүйцэтгэх засаглалын хүрээнд бүрэлдэн тогтсон Үйлдвэрлэл худалдаа, нөөцийн яам тэргүүтэй экспортыг дэмжих байгууллагуудын тогтолцоо нь үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний экспортод тулгардаг төрөл бүрийн саад бэрхшээлийг олон аргаар хөнгөвчилж байна. Энэхүү хүчирхэг тогтолцоо нь тус улсын эдийн засгийн түүхэн хөгжлийн явцад өнөөгийн төрхөө олжээ.

Арга зүй

Судалгааны эхний хэсэгт БНСУ-ын аж үйлдвэрлэл, экспортын хөгжилд Засгийн газрын үүрэг оролцоо ямар хэмжээнд байсныг баримт бичгийн судалгаанд үндэслэн товчхон авч үзсэн.

Хоёрдугаар хэсэгт БНСУ-ын өнөөгийн Засгийн газрын харьяанд буй экспортыг дэмжих байгууллагуудын чиг үүрэг, уялдаа холбоо, бодлого төлөвлөх болон хэрэгжүүлэх үйл явцыг баримт бичгийн болон контент анализын аргаар судалсан. Улмаар эдгээр байгууллагууд нэгдсэн удирдлага, нарийн зохион байгуулалтын дор

тогтолцоо хэлбэрээр хэрхэн үр ашигтай ажиллаж байгааг тодруулахыг оролдсон.

Гуравдугаар хэсэгт Монгол Улсын экспортыг дэмжих үүрэгтэй байгууллагуудын өнөөгийн нөхцөл байдал, экспортод тулгамдаж буй нийтлэг асуудлуудыг баримт бичгийн болон контент анализын аргаар ерөнхий байдлаар судалсан. Улмаар БНСУ-ын сайн жишээнд үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын экспортыг дэмжих арга барил, үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулж болохуйц саналуудыг дэвшүүлсэн.

1. БНСУ-ын экспортыг дэмжих бодлогын түүхэн замнал

БНСУ нь 1960-аад оны эхээс экспортод чиглэсэн аж үйлдвэрлэлийг хөгжлийн замаар сонгож, дотоод бүх нөөц боломжоо үүнд чиглүүлжээ. Ерөнхийлөгч Пак Жөн Хий тус улсын эдийн засгийн урт болон дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх зорилгоор төсөв, татвар, аж үйлдвэрлэл, гадаад худалдаатай холбоотой бүх эрх мэдлийг Эдийн засгийн төлөвлөлтийн хороонд³ төвлөрүүлэв. Улмаар холбогдох чиг үүрэг бүхий байгууллагуудыг нэгдсэн бодлогын хүрээнд харилцан уялдаатай, үр өгөөжтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Өөрөөр хэлбэл экспортыг дэмжих тогтолцооны суурийг тавьжээ.

Төлөвлөлтийн хороо нь эдийн засгийн хөгжлийг 5, 5 жилээр төлөвлөн 1962-1992 он

хүртэл 6 удаа хэрэгжүүлсэн байна. Энэхүү төлөвлөгөөнд аж үйлдвэрлэл, экспортыг дэмжих бодлого хөтөлбөрүүдийг багтаажээ. Тухайлбал 1960 оноос хөнгөн үйлдвэрлэл, 1970 оноос хүнд болон химийн үйлдвэрлэлийг дэмжих, 1975 оноос үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнд гадаад зах зээлийн орон зай, худалдааны суваг бий болгоход чиглэсэн хөтөлбөрүүдийг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Аж үйлдвэрлэл, гадаад худалдааг дэмжих үүрэгтэй мэргэшсэн агентлагуудыг тухайн цаг үеийн бодлого, хөтөлбөртэй уялдуулан үүсгэн байгуулжээ. Бодлого хөтөлбөрүүдийн хүрээнд улсын дотоод санхүүгийн нөөцийг төрийн хяналт, зохицуулалтаар экспортын аж үйлдвэрлэлийн салбар луу чиглүүлсний дээр санхүүгийн эрсдэлийг төр хуваалцаж байв⁴. Төрийн хяналт,

² <https://stat.kita.net/stat/world/trade/CtrImpExpList.screen>

³ [경제기획원 \(naver.com\)](http://naver.com)

⁴ Taejong Kim, Soogil Young “Secrets of an Economic Miracle Lessons for Sustainable Development from South Korea”, 2019, p.44

төлөвлөлтийн хүрээнд аж үйлдвэрлэлийн сонгосон салбарыг эрчимтэй дэмжих замаар экспортыг богино хугацаанд хурдтай өсгөдөг хөгжлийн энэхүү загварыг АНУ-ын эдийн засагч Чалмерс Жонсон Хөгжлийн улс (Developmental state) нэрээр анхлан томъёолж эрдэм шинжилгээний эргэлтэд оруулжээ. Япон улсаас үүдэлтэй хөгжлийн энэхүү загвараар БНСУ,

Сингапур, Тайланд, Тайван, Малайз зэрэг Азийн улс орнууд амжилттай замнасан түүхтэй. 1960-1990 оны хооронд БНСУ-ын аж үйлдвэрлэл нь хөгжлийн эхлэлийн болон өсөлтийн үе шатыг туулсан бөгөөд энэ 30 жилийн хугацаанд тус улсын экспортын дүн даруй 1980 дахин өссөн бөгөөд жилийн дундаж өсөлт 50 орчим хувьтай байжээ.

Хүснэгт 1. БНСУ-ын экспортын дүн, өсөлтийн хувь хэмжээ (таван жилээр)

Он	Экспортын дүн (мянган ам. доллар)	Өсөлт (%)	Жилийн дундаж өсөлт (%)
1960	32,827		
1965	175,082	433	86.67
1970	835,185	377	75.41
1975	5,081,016	508	101.67
1980	17,504,862	245	48.90
1985	30,283,122	73	14.60
1990	65,015,731	115	22.94
1995	125,057,988	92	18.47
2000	172,267,510	38	7.55
2005	284,418,743	65	13.02
2010	466,383,762	64	12.80
2015	526,756,503	13	2.59
2020	512,498,038	-3	-0.54
2023	632,225,824	23	4.67

Эх сурвалж: <https://stat.kita.net/stat/kts/sum/SumImpExpTotalList.screen#>
 БНСУ-ын худалдааны хорооны экспортын статистик үзүүлэлт

Төрийн эрчимтэй дэмжлэгийн үр дүнд үйлдвэрлэгчдийн потенциал нэмэгдэж, экспортын хэмжээ харьцангуй богино хугацаанд дорвитой өссөн ч аж үйлдвэрлэлийн салбарт чанаргүй зээл өсөх, бүтээмж буурах, инфляцын түвшин нэмэгдэх зэрэг сөрөг үр дагаврууд гарч, экспортын бус аж үйлдвэрлэл болон нийгмийн хөгжил хойш тавигджээ. Мөн 1979 оны газрын тосны хоёр дахь хямрал тус улсын аж үйлдвэрлэл, санхүүгийн салбарын эмзэг байдлыг илрүүлж өгчээ⁵. Энэ байдалд дүгнэлт хийж нийгэм-эдийн засгийг тэнцвэртэй хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үүднээс төрийн мэдлийн арилжааны банкнуудыг хувьчлах, импортын тарифыг бууруулах,

гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт хөрөнгө оруулах зэрэг арга хэмжээ авчээ⁶. Улмаар санхүү, татварын дэмжлэгийг аж үйлдвэрлэлийн салбараас технологи, инновац, боловсролын салбар руу чиглүүлэв. Өөрөөр хэлбэл эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, зах зээлийн жамаар хөгжих боломжийг нэмэгдүүлсэн. Энэ үүднээс авч үзвэл 1990-ээд оноос хойших эдийн засгийн хөгжлийн загвар нь либерализмд илүү ойртжээ. Ковидын хямрал нүүрлэсэн 2020 он зэрэг цөөн хэдэн жилийг эс тооцвол экспортын хэмжээ тууштай нэмэгдсээр байна.

⁵ Yun-Hwan Kim, "The role of government in export expansion in the Republic of Korea: A revisit", 1994, p.11

⁶ Jong-Dae Park, "Re-Inventing Africa's Development: Linking Africa to the Korean Development Model", 2019, p.191

Өнгөрсөн зууны 90-ээд он хүртэл хэрэгжүүлсэн бодлого хөтөлбөрүүд нь томоохон корпорацуудад боломж, давуу талуудыг олгосны дүнд Самсунг, Хёндэ зэрэг үйлдвэрлэгчид дотоод зах зээлд үлэмж давуу байр суурь эзлэх болсон ч нөгөө талдаа жижиг дунд үйлдвэрлэгчид зах зээлээс шахагдах, орлого тэгш бусаар хуваарилагдах зэрэг зарим сөрөг үр дагаврууд гарах болсон⁷. Тиймээс өнөөгийн Засгийн газрын бодлого нь нэгдүгээрт, дотоод зах зээл дэх корпорацуудын

давамгайллаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн тэнцвэргүй байдлыг арилгах үүднээс жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, хоёрдугаарт, өсөх ирээдүйтэй шинэ технологи, IT, инновацыг дэмжих замаар улс орны эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэж байна. Тиймээс гадаад худалдааг хариуцсан Үйлдвэрлэл худалдаа, нөөцийн яам нь Жижиг дунд үйлдвэрлэл, гарааны бизнесийн яамтай⁸ (ЖДҮЯ) экспортыг дэмжихэд нягт хамтран ажиллах болжээ.

2. БНСУ-ын экспортыг дэмжих тогтолцоо

БНСУ-ын экспортыг дэмжих стратегийг Үйлдвэрлэл худалдаа, нөөцийн яам болон Төлөвлөлт, сангийн яам гаргадаг. Төлөвлөлт, сангийн яам нь улс орны хөгжлийн стратеги, эдийн засгийн бодлого, төсвийн бодлого төлөвлөн хэрэгжүүлдэг байгууллага юм. Эдийн засгийн бодлогын хүрээнд экспортыг дэмжих бодлого төлөвлөхөд уг яам оролцдог байна. Үйлдвэрлэл худалдаа, нөөцийн яам нь гадаад худалдаа болон аж үйлдвэрийн бодлого төлөвлөн хэрэгжүүлдэг байгууллагын хувиар экспортыг дэмжих бодлого төлөвлөхөд гол үүрэгтэй оролцдог. Үүнээс гадна уг яам нь бодлого хөтөлбөрөө хэрэгжүүлэх, хянах, нэгтгэн дүгнэх зэрэг ажлуудыг хариуцдаг учир тус улсын экспортыг дэмжих ажилд гол үүрэг гүйцэтгэдэг.

Үйлдвэрлэл, худалдаа, нөөцийн яам (ҮХНЯ) нь гадаад худалдаа, аж үйлдвэрлэл, эрчим хүч болон аж үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эдийн нөөц бүрдүүлэхтэй холбогдсон үндсэн 3 чиглэлийн бодлого төлөвлөн хэрэгжүүлдэг⁹. Тус улс нь байгалийн нөөц баялаг багатай учир импортоор авсан түүхий эдийг боловсруулж, нэмүү өртөг шингээн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлээд, түүнийгээ экспортолж орлого олдог. Өөрөөр хэлбэл аж үйлдвэрлэл нь гадаад худалдаанаас маш өндөр хамааралтай. Тиймээс худалдаа, үйлдвэрлэл, түүхий эдийн нөөц

бүрдүүлэх 3 ажил үүргийг нэг яаманд хариуцуулжээ. Үндсэн чиг үүргийн дагуу тус яам нь аж үйлдвэрлэл, гадаад худалдаа, эрчим хүчний болон аж үйлдвэрлэлийн түүхий эдийн нөөц бүрдүүлэх 3 газар, холбогдох хэлтсүүд, харьяа агентлагуудаас бүрдэнэ. Аж үйлдвэрлэлийн газар нь салбарын бодлого төлөвлөх, хүний нөөцийг чадавхжуулах, технологийг хөгжүүлэх, стандарт тогтоох болон хянах чиг үүрэгтэй бол Гадаад худалдааны газар нь худалдааны бодлого төлөвлөх, чөлөөт бүсийн үйл ажиллагааг удирдах, чөлөөт худалдааны хэлэлцээр хийх, хөрөнгө оруулалтын бодлого төлөвлөх, хөрөнгө оруулалт татах чиг үүрэгтэй.

ҮХНЯ нь бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, дүгнэх үүрэгтэй бол бусад 18 яам, тэдний харьяа агентлагууд экспортыг дэмжих ажилд өөр өөрийн чиг үүргийн хүрээнд их бага хэмжээгээр оролцдог. Товчоор хэлбэл, БНСУ-ын гүйцэтгэх засаглал нь бүхэлдээ экспортыг дэмжих ажилд оролцдог байна. Экспортын бодлого тодорхойлох, экспортыг нэмэгдүүлэх, экспортод тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэх зорилготой БНСУ-ын гүйцэтгэх засгийн газрын хурал зөвлөгөөн нь гурван түвшинд явагддаг байна. Доод шатандаа дэд сайд, 18 яамдын газрын дарга нарын түвшинд, дунд шатандаа ҮХНЯ болон Төлөвлөлт, сангийн яамны сайд нарын түвшинд, дээд шатандаа

⁷ Forms of government support for national production and export in the Republic of Korea | Journal of International Studies (mongoliajol.info)

⁸ [중소벤처기업부 \(mss.go.kr\)](http://mss.go.kr)

⁹ [산업통상자원부 \(motie.go.kr\)](http://motie.go.kr)

ерөнхийлөгчийн түвшинд хэрэгждэг байна. Доод шатны хуралд салбар бүрийн экспортод тулгамдсан асуудлыг тодорхойлох, экспортын тайланг нэгтгэх зэрэг ажил хийгддэг бол дунд шатны хуралд экспортын гүйцэтгэлийг хянах, экспортод тулгамдаж буй гол асуудлуудыг үнэлэх, шийдэл боловсруулах ажил хийгддэг байна. **Ерөнхийлөгчийн удирддаг экспортын стратегийн хурал нь экспортын үндсэн бодлогыг тодорхойлохын** сацуу яамдын сайд нараас гадна хувийн хэвшлийн төлөөллийг

оролцуулах замаар экспортыг нэмэгдүүлэх, экспортод тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх боломжтой байдгаараа өндөр ач холбогдолтой юм. БНСУ-ын өнөөгийн ерөнхийлөгч Юн Сок Ёль нь ажил үүргээ хүлээн авсан 2022 оны 5 сараас хойш 4 удаа экспортын стратегийн хурал хийгээд байна. Ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглал болон хувийн хэвшлийг экспортод чиглүүлэх, манлайлах үүрэг гүйцэтгэдэг байна.

Зураг 1. БНСУ-ын Засгийн газрын экспортын хурал, хэлэлцүүлгийн процесс



Эх сурвалж:

<https://www.motie.go.kr/attach/viewer/c145c495367b58bbf1f424cc84b36df0/bfab28e9e16a1fbc959fa9d192124c62/9a9db098b587ee18b321c826f3707a49> ҮХНЯ-ны 2023 оны Экспортыг дэмжих үйл ажиллагааны удирдамж, 7 дугаар нүүр.

Гадаад худалдааны бодлого тодорхойлон хэрэгжүүлэгч гол байгууллагын хувиар ҮХНЯ нь жил бүр улс даяар хэрэгжүүлэх экспортыг дэмжих үйл ажиллагааны удирдамжийг¹⁰ боловсруулж гаргадаг. Удирдамжид өмнөх жилийн улс орны экспортын гүйцэтгэлийн үнэлгээ, тухайн жилийн экспортыг дэмжих төлөвлөгөө, цаашдын чиг хандлага, дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, мөн тухайн жилд Засгийн газрын яам, агентлаг, орон нутгийн удирдах байгууллагуудын экспортыг дэмжих хүрээнд хэрэгжүүлэх ажил, төсөвт өртөг, хамрагдах шалгуур, холбогдох хаяг зэргийг зааж өгдөг. 2023 оны экспортыг дэмжих үйл ажиллагаанд ҮХНЯ болон ЖДҮЯ-наас гадна 8


яам, түүний харьяа агентлагууд, орон нутгийн удирдах байгууллагууд оролцжээ. ҮХНЯ-ны удирддаг Экспортыг дэмжих байгууллагуудын зөвлөл нь Экспортын стратеги төлөвлөгөөнд үндэслэн бусад 18 яам, агентлагууд экспортыг дэмжихэд ямар үүрэгтэй хэрхэн оролцох зэрэг асуудлуудыг зөвлөлдөн шийддэг байна. Мэдээллийн технологи, хөдөө аж ахуй, загас агнуур зэрэг мэргэжлийн онцлог бүхий салбаруудын хувьд мэргэшсэн яам агентлагуудын оролцоог хангах замаар тухайн салбарын үйлдвэрлэгчдийн экспортыг дэмжиж байна. Тухайлбал 2023 оны удирдамжийн 283-286 дугаар хуудсанд Шинжлэх ухаан, технологи, мэдээлэл, харилцаа холбооны яам нь өөрийн

¹⁰ POINT 정책정보포털 | 상세정보 (nl.go.kr)

харьяа Мэдээлэл, харилцаа холбооны бизнесийг дэмжих агентлагаар дамжуулан хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн агуулга, үнийн дүн, хамрагдах шалгуур, холбогдох хаягийг зааж өгсөн байна. Орон нутгийн удирдах байгууллагуудад өөрийн харьяанд буй үйлдвэрлэгчдийн экспортыг дэмжих хүрээнд тодорхой эрх мэдэл, үүрэг, санхүүжилтийг олгодог байна. Энэхүү удирдамж нь бизнес эрхлэгчдэд Засгийн газрын тухайн жилийн экспортыг дэмжих

хөтөлбөрүүдийн мэдээллийг нэг дороос бүгдийг харах, харьцуулан сонгох боломж олгодог байна. Мөн хөтөлбөр хэрэгжүүлэгч агентлагуудын холбогдох хаяг, байршил зэрэг шаардлагатай мэдээллийг харж болно. Экспортыг дэмжих бодлого төлөвлөх, хөтөлбөр хэрэгжүүлэх, хянах, дүгнэх зэрэг бүх ажлыг нэг яам гардан хэрэгжүүлэх нь үйл ажиллагааны үр өгөөж өндөр байх үндэс болдог байна.

Зураг 2. БНСУ-ын экспортыг дэмжих бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх процесс



Гадаад худалдааг дэмжих чиг үүрэгтэй 7 хэрэгжүүлэгч агентлаг ҮХНЯ-нд харьяалагддагаас 5 нь экспортыг дэмжихэд гол үүрэгтэй оролцдог. Эдгээр агентлагуудыг тус улсын Засгийн газар 1960-аад оноос хойш хэрэгжүүлсэн аж үйлдвэрлэл, экспортыг дэмжих бодлого хөтөлбөртэй уялдуулан цаг үеийн шаардлагаар байгуулж байв. Тухайлбал Солонгосын худалдааны хороог Японы колоничлолоос чөлөөлөгдсөний дараа гадаад худалдааг дэмжих зорилгоор байгуулжээ. 1960-аад оноос хөнгөн үйлдвэрлэлийн экспортыг

дэмжих бодлого хэрэгжүүлж эхлэхтэй зэрэгцэн Худалдаа хөрөнгө оруулалтын агентлагийг, хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг төлөвлөх явцад Туршилт судалгааны хүрээлэн, Аж үйлдвэрлэлийн технологи туршилтын лабораторийг тус тус байгуулж байв. Дэлхийн худалдааны байгууллагад элсэхийн өмнө буюу гадаад худалдаанд харьцангуй нээлттэй бодлого баримталж эхлэхтэй зэрэгцэн гадаад худалдааны эрсдэлийг бууруулах зорилгоор Худалдааны даатгалын корпорацыг байгуулжээ.

Хүснэгт 2. ҮХНЯ-ны харьяа экспортыг дэмжих агентлагууд

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байгуулсан он	Эрх зүйн баримт бичиг
1	Солонгосын худалдааны хороо ¹¹	Сургалт зөвлөгөө, судалгаа, тайлан мэдээ гаргах, үзэсгэлэн зохион байгуулах /KOEХ mall/ Худалдааг хөнгөвчлөх: ЧХХ-ийн нэг цонхны үйлчилгээ, UtradeHub цахим худалдааны нэг цонхны үйлчилгээ	1946	Иргэний хууль
2	Солонгосын худалдаа, хөрөнгө оруулалтын агентлаг ¹²	Зах зээл нээх: Хилийн чанадад компанийг төлөөлөх, бүтээгдэхүүн сурталчлах, зуучлах, судалгаа хийх, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, харилцагчийг судлах, тендерийн мэдээлэл дамжуулах, хөрөнгө оруулалт татах	1962	Солонгосын худалдаа хөрөнгө оруулалтыг дэмжих хууль
3	Солонгосын туршилт судалгааны хүрээлэн ¹³	Технологийн дэмжлэг: Бараа бүтээгдэхүүнийг импортлогч улсын стандарт шаардлагад нийцүүлэхэд туслал, лабораториудыг ААН-үүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах	1969	Улсын стандартын тухай хууль
4	Худалдааны даатгалын корпорац ¹⁴	Экспортын, импортын, валютын ханшийн эрсдэлээс сэргийлэх болон хөрөнгө оруулалтын даатгал. Хамтран ажиллах гадаад компанийн санхүүгийн чадварыг судлах	1992	Солонгосын худалдааны даатгалын тухай хууль
5	Солонгосын үзэсгэлэн худалдааны холбоо ¹⁵	Маркетингийн дэмжлэг: Үйлдвэрлэгчдийг дотоод болон гадаадад зохион байгуулагддаг үзэсгэлэнд оролцуулах, гадаад хамтрагчидтай зуучлах	2002	Үзэсгэлэн худалдааг дэмжих тухай хууль

Яамны экспортыг дэмжих үйл ажиллагаа, бодлого хөтөлбөрийг энэ 5 агентлаггүйгээр төсөөлөхөд бэрх. Олон жилийн туршлагатай, салбартаа мэргэшсэн, дотоодод өндөр нэр хүндтэй эдгээр агентлаг нь тус тусын чиг үүргийн хүрээнд олон төрлийн экспортыг дэмжих үйлчилгээ үзүүлдэг. Тухайлбал КОТРА нь дэлхийн 84 улсад байрших 126 салбараар дамжуулан үйлдвэрлэгчдэд гадаад зах зээлийн орон зай бий болгох замаар борлуулалтыг дэмжих, худалдааны суваг нээхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Энэ хүрээнд компанийг гадаадад төлөөлөх, судалгаа хийх, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, бараа бүтээгдэхүүн сурталчлах, хөрөнгө оруулалт татах зэрэг

үндсэн 50 гаруй төрлийн үйлчилгээ үзүүлж байна. Тухайлбал КОТРА нь байршиж буй улсын зах зээлийн судалгааг хийсний үндсэн дээр тухайн улсад нэвтрэх хүсэлтэй ААН-үүдэд холбогдох мэдээллийг өгөх, төрийн худалдан авалтын мэдээллийг дамжуулах, дотоодын бараа бүтээгдэхүүнийг тухайн улсад сурталчлах, гааль, худалдааны үйл ажиллагааг төлөөлөн гүйцэтгэх зэрэг ажил хийдэг. КОТРА-гийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газрын зуучлалаар БНСУ-ын олон компани Монгол Улсын зах зээлд нэвтэрч үйл ажиллагаа явуулж иржээ. Үүний заримаас дурдвал БНСУ-ын Самсунг компаниас хэрэгжүүлсэн Ухаа худгаас Гашуун сүхайт хүртэлх 217 км төмөр

¹¹ [한국무역협회-KITA.NET](http://www.kita.net)

¹² [KOTRA 무역투자 24](http://www.kotra.or.kr)

¹³ [KTR](http://www.ktr.or.kr)

¹⁴ [한국무역보험공사 \(ksure.or.kr\)](http://www.ksure.or.kr)

¹⁵ <https://www.akei.or.kr/>

замын ажил, Хөшгийн хөндийн шинэ нисэх буудлын барилга угсралтын ажил, мөн нийтийн тээврийн Улаанбаатар смарт карт зэрэг төслүүд хэрэгжжээ. Сүүлийн жилүүдэд БНСУ-ын мэдээллийн технологийн олон компани КОТРА-гийн үйл ажиллагааны үр дүнд Монгол Улсад ажиллаж байна.

Солонгосын худалдааны хороо нь гадаад худалдааг хөнгөвчлөх зорилгын хүрээнд Utradehub цахим худалдааны платформ, Чөлөөт худалдааны хэлэлцээрийн нэг цонхны цахим үйлчилгээг үзүүлдэг. Энэ нь үйлдвэрлэгчдэд гадаад худалдаа хийхэд тулгардаг олон төрлийн цаг хугацаа, хүч хөдөлмөр шаардсан ажиллагааг ажлын байрнаасаа онлайн ажил хийх боломж олгож өгдөг давуу талтай. Тухайлбал Utradehub платформ нь төрийн байгууллагуудаас авдаг экспортын зөвшөөрөл, банкны гүйлгээний баримт, тээврийн лавлагаа, гаалийн мэдүүлэг бөглөх болон илгээх зэрэг олон ажиллагааг цахимаар хийх боломж олгодог аж. Чөлөөт худалдааны хэлэлцээрийн нэг цонхны үйлчилгээ нь тухайн үлстэй байгуулсан хэлэлцээрийн хөнгөлөлтөд хэрхэн хамрагдахтай холбоотой бүх төрлийн зөвлөгөөг нэг цонхоор авах боломж олгодог байна. Мөн Худалдааны хорооны харьяа Худалдааны академи, Худалдааны бодлогын судалгааны хүрээлэн, КОЕХ mall олон улсын худалдааны төв зэрэг салбар байгууллагууд нь гадаад худалдааг дэмжих, хөнгөвчлөхөд чиглэсэн олон төрлийн ажил хийдэг.

Туршилт судалгааны хүрээлэн нь дэлхийн 40 улсын 180 гаруй туршилт судалгаа, стандартчиллын байгууллагуудтай хамтран ажиллаж, тухайн улсын дотоодод тавигддаг чанарын стандарт шаардлагуудыг нутагшуулах ажлыг хийдэг. Энэ хүрээнд дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудын CE, NRTL, RoHS зэрэг 160 гаруй стандартыг хангахтай холбоотой туршилт судалгааг дотоодод хийж батламж олгож байна. Энэ үйлчилгээ нь бараа бүтээгдэхүүнээ импортлогч талын стандарт шаардлагад нийцүүлэхийн тулд тухайн улсыг зорих, дээж илгээх, бичиг баримт орчуулах зэрэг олон ажлыг хөнгөвчилж өгдөг давуу талтай. Тухайлбал БНСУ-ын А компани АНУ руу богино холбооны станц экспортлохын тулд АНУ-ын зүгээс энэ төрлийн бүтээгдэхүүний импорт

тавигддаг техникийн болон эрүүл ахуйн стандартыг хангахтай холбоотой лабораторийн туршилтыг Туршилт судалгааны хүрээлэнд хийж батламж буюу экспорт хийх зөвшөөрөл авч болох аж.

Худалдааны даатгалын корпорац нь үйлдвэрлэгчдийг гадаад худалдааны эрсдэлээс хамгаалах үйлчилгээ үзүүлдэг. Хувийн хэвшлээс хэрэгжүүлэх боломжгүй өндөр эрсдэл бүхий уг салбарыг төр хариуцах замаар дотоодын үйлдвэрлэгчдийн эрсдэлийг нуруундаа үүрч иржээ. Экспортын даатгал, импортын даатгал, валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэлээс сэргийлэх даатгалын үйлчилгээгээр дамжуулан үйлдвэрлэгчдийг худалдааны эрсдэлээс хамгаалдаг. Мөн бизнесийн харилцаанд орж буй гадаад хамтрагчийн төлбөрийн чадварын судалгааг хийж өгдөг байна. Түүнээс гадна гадаад болон дотоодод хэд хэдэн төрлийн төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ үзүүлдэг.

Үзэсгэлэн худалдааны хороо нь дотоодод болон гадаадад БНСУ-ын бараа бүтээгдэхүүнийг сурталчлах зорилго бүхий төрөл бүрийн үзэсгэлэн зохион байгуулдаг мэргэшсэн байгууллага юм. Үзэсгэлэнгээр дамжуулан бараа сурталчлах, үйлдвэрлэгчдэд гадаад зах зээлийн орон зай бий болгох, зуучлах, хөрөнгө оруулалт татах зэрэг ажил хийдэг байна. Мөн дотоод, гадаадад зохион байгуулагддаг бүх төрлийн үзэсгэлэнгийн мэдээллийг үйлдвэрлэгчдэд хүргэдэг.

Агентлагууд нь өөрсдийн үндсэн үйлчилгээг бизнес эрхлэгчдэд тогтмол үзүүлэхээс гадна тухайн жилийн Засгийн газрын бодлогын хүрээнд төлөвлөгдсөн экспортыг дэмжих багц хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлдэг. Засгийн газрын экспортыг дэмжих зорилготой хөтөлбөрт хамрагдсан тохиолдолд хэрэгжүүлэгч агентлагуудын үйлчилгээний үндсэн үнэ 50-70 хувиар хямдардаг онцлогтой. БНСУ-ын үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын процесс нь ҮХНЯ-ны харьяа дээрх 5 агентлагаар зайлшгүй дамждаг. Учир нь эдгээр агентлагууд нь өөрсдийн үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд аж ахуйн нэгжүүдийн экспортод тулгардаг үндсэн саад бэрхшээлүүдийг шийдвэрлэж, хөнгөвчилж, гарч болзошгүй эрсдэлийг бууруулж өгдөг. Товчоор хэлбэл ҮХНЯ-ны

харьяа агентлагууд нь бизнес эрхлэгчдэд экспортын үйл ажиллагааны хөтөч, зохицуулагч механизмын үүргийг гүйцэтгэж байна.

3. Монгол Улсын экспортыг дэмжих үүрэгтэй байгууллагуудын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдэл

Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яамны (ЭЗХЯ) тэргүүлэх чиглэлд хөгжлийн бодлого, тэр дундаа бүсчилсэн хөгжил, худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого төлөвлөх тухай ажлуудыг оруулжээ. Өнөөгийн байдлаар ЭЗХЯ нь аж үйлдвэрлэлийн томоохон төслүүдийн бүтээн байгуулалтад гол анхаарлаа хандуулж байна. Эдгээр төслүүдийн дийлэнх нь уул уурхайн эрдэс түүхий эд боловсруулахад чиглэгдэж байгаагаас үүдэн уул уурхайн бус үйлдвэрлэлийг дэмжих ажил орхигдож байна. Манай улсын хөнгөн үйлдвэрлэлийн хамгийн том салбар болох мал аж ахуй, газар тариалангийн гаралтай бүтээгдэхүүний

үйлдвэрлэлийг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хариуцдаг. Тус яамны үйл ажиллагаанаас харвал хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх үйлдвэрлэлийг технологиор дэмжих бодлогын чанартай ажил дутагдалтай байна.

ЭЗХЯ болон Гадаад харилцааны яам нь гадаад худалдаа хариуцсан газар, хэлтэстэй. Хоёр яамны цахим хуудаснаас харвал аль аль нь гадаад худалдааны бодлого төлөвлөх үүрэгтэй. Гэвч яамдын төлөвлөн хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөр, уялдаа холбоо, ажил үүргийн хуваарилалт хэрхэн явагддаг нь тодорхойгүй байна.

Хүснэгт 3. Монгол Улсын экспортыг дэмжих байгууллагууд

№	Байгууллагын нэр	Харьяалал	Үйл ажиллагааны чиглэл	Байгуулагдсан огноо	Эрх зүйн баримт бичиг
1	Худалдаа аж үйлдвэрийн танхим	Төрийн бус байгууллага	Гарал үүслийн гэрчилгээ, сургалт зөвлөгөө, бизнес зуучлал, арбитр, үзэсгэлэн зохион байгуулах	1960	ХАҮТ-ийн тухай хууль
2	Жижиг дунд үйлдвэрийн газар	ХХААХҮЯ	ЖДҮ-ийн санхүүжилт	1993	ЖДҮ-ийг дэмжих тухай хууль
3	Хөгжлийн банк	Эдийн засгийн хөгжлийн яам	Төслийн санхүүжилт	2011	Хөгжлийн банкны тухай хууль
4	Нийслэлийн ЖДҮ-ийг дэмжих төв	Улаанбаатар хотын захиргаа	Сургалт зөвлөгөө өгөх, чиглүүлэх (Бүх дүүрэгт салбартай)		
5	Зээлийн батлан даалтын сан	Засгийн газар	Гадаад худалдааны эрсдэлийг бууруулах	2021	ЗДБС-гийн тухай хууль
6	Үндэсний давхар даатгал ХХК	Сангийн яам	Зээлд шаардлагатай барьцаа хөрөнгийн 60 хувьд баталгаа гаргах	2014	

Яамдаас гадна үйл ажиллагааны чиг үүрэгт нь экспортыг дэмжих утга агуулга орсон хэд хэдэн байгууллага ажиллаж байна. Төрийн байгууллагууд нь зээл олгох, худалдааны


эрсдэлийг бууруулах, сургалт зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг бол Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь гадаадын хэд хэдэн улсад төлөөлөгчтэй бөгөөд бизнес зуучлах, гэрчилгээ

олгох, үзэсгэлэн зохион байгуулах зэрэг ажил хийдэг аж. Монгол Улсын экспортыг дэмжих үүрэгтэй эдгээр байгууллага нь тус бүр өөр харьяалалтай ажиллаж байна.

БНСУ-ын хувьд нэг яам экспортын бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, дүгнэх ажлыг гардан хэрэгжүүлж байна. Тэгвэл Монгол Улсын хувьд гадаад худалдаа болон аж үйлдвэрлэлийг хариуцсан 4 яам ажиллаж байгаа бөгөөд экспортыг дэмжих нэгдсэн бодлого одоогоор алга. Яамдын тус тусын харьяа агентлагуудаар

дамжуулан хэрэгжүүлж буй дийлэнх төсөл хөтөлбөр нь хөнгөлөлттэй зээл олгоход чиглэж байна. Эндээс харахад юуны өмнө манай улсад нэг удирдлага бүхий экспортыг дэмжих үр ашигтай тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна. Улмаар экспортыг дэмжих үүрэгтэй хэрэгжүүлэгч байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын дор харилцан уялдаатай, үр өгөөжтэй, хүртээмжтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй.

Зураг 3. Монгол Улсын экспортыг дэмжих үйл явц



Монгол Улсад экспорт хийхэд тулгардаг бэрхшээлүүд: Дэлхийн банкны санхүүжилтээр Экспортыг дэмжих төвийн 2020 онд хийсэн судалгаагаар аж ахуйн нэгжүүдэд экспортын үйл ажиллагаа эрхлэхэд хамгийн их тулгардаг 3 гол саад бэрхшээлд, нэгдүгээрт, экспортыг дэмжсэн хууль эрхзүйн орчин, бодлого хангалтгүй, хоёрдугаарт, хөрөнгө мөнгө, санхүүжилтийн дутагдал, гуравдугаарт, гадаад зах зээл дээр Монгол брэндигийн нэгдсэн бодлого, зохицуулалт, дэмжлэг хангалтгүй зэрэг багтсан байна¹⁶.

НҮБ-ын худалдаа хөгжлийн бага хурлын (UNCTAD) судалгаагаар гадаад зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх нь экспортын

өсөлтөд гол нөлөө үзүүлдэг тухай өгүүллийн эхэнд дурдсан. Мөн манай улсын аж ахуйн нэгжүүд бараа бүтээгдэхүүн экспортод гаргахад дунджаар 11 төрлийн бичиг баримт бүрдүүлж, 168 цаг зарцуулдаг тухай судалгаа байдаг¹⁷. Эндээс дүгнэж үзвэл экспорт хийхэд тулгардаг дараах хэдэн нийтлэг саад бэрхшээл байна. Үүнд:

1. Хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, бодлого хөтөлбөр төлөвлөн хэрэгжүүлэх төрийн байгууллагын үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх шаардлага байна.
2. Хөрөнгө мөнгө, санхүүгийн бэрхшээл
3. Гадаад зах зээлд монголын бараа бүтээгдэхүүний онцлог давуу талыг таниулах,

¹⁶ Судалгаа (edp.mn)

¹⁷ PowerPoint Presentation (mongolbank.mn)

гадаад зах зээлийн орон зай, худалдааны суваг бий болгох үйлчилгээ дутмаг

4. Экспорт хийх бүртгээ авдаг төрийн болон бусад байгууллагын тодорхойлолт, зөвшөөрөл авахад ихээхэн цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулдаг байдал.

БНСУ-ын ҮХНЯ тэргүүтэй экспортыг дэмжих байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны жишээнд үндэслэн, Монгол Улсад экспортыг дэмжих төрийн байгууллагын үр ашигтай тогтолцоог байгуулах замаар үндэсний үйлдвэрлэгчдийн экспорт хийхэд тулгардаг саад бэрхшээлүүдийг шийдвэрлэх боломж байна. Үүнд:

1. Хууль эрх зүйн орчин, бодлогын шаардлага: Экспортыг дэмжих хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, нэгдсэн бодлого хөтөлбөр төлөвлөн хэрэгжүүлэх мэргэшсэн яам байгуулах шаардлага байна. Экспорт нь гадаад худалдаа болон аж үйлдвэрлэлийн бодлого хөтөлбөр, энэхүү хоёр салбар хоорондын хамтын ажиллагааны үр дүнд бий болдог. Тиймээс БНСУ-ын ҮХНЯ-ны жишээгээр уг хоёр салбарыг нэг яам хариуцах нь бодлого хөтөлбөрийн үр өгөөж өндөр байх үндэс болно. Манай улсын аж үйлдвэрлэл болон гадаад худалдааны салбар нь харьцангуй цомхон учир нэг яам хариуцан хэрэгжүүлэх боломж бий.
2. Үйлдвэрлэгчдэд тулгардаг санхүүгийн бэрхшээл: Өнөөгийн байдлаар ЖДҮ-ийн газар болон Хөгжлийн банк нь экспортын зээл олгож байна. Зарим арилжааны банкнууд ч экспортыг дэмжих зээл олгодог. Мөн гадаад

худалдааны санхүүгийн эрсдэлийг бууруулах, зээлийн баталгаа гаргах үүрэгтэй хоёр байгууллага ажиллаж байна. Тус тусын харьяалалтай эдгээр олон байгууллагыг нэгдсэн бодлогын хүрээнд удирдан чиглүүлж, харилцан уялдаатай, үр өгөөжтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлбэл үйлдвэрлэгчдэд тулгардаг санхүүгийн асуудал цэгцрэх боломжтой.

3. Монгол брэндигийн нэгдсэн бодлого зохицуулалт: Монгол Улсын онцлог, давуу талтай бараа бүтээгдэхүүнийг гадаадад таниулан сурталчлах, гадаад зах зээлийн орон зай, худалдааны суваг бий болгоход БНСУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалтын агентлагийн гадаад дахь салбаруудаар дамжуулан хэрэгжүүлдэг зарим төрлийн үйл ажиллагааг жишиг болгон нэвтрүүлэх боломжтой.
4. Экспортын зөвшөөрөл, тодорхойлолт авахад тулгардаг бэрхшээл: Төрийн болон холбогдох бусад байгууллагуудын зөвшөөрөл, тодорхойлолтыг экспорт хийх бүртгээ авах шаардлагатай байдаг аж. БНСУ-ын Худалдааны хорооны Urtadehub нэг цонхны цахим үйлчилгээг нэвтрүүлэх замаар цаг хугацаа, хүч хөдөлмөр шаардсан уг ажлыг хөнгөвчлөх боломж байна. Мөн импортлогч талаас тавигддаг технологийн стандарт шаардлагыг хангахад туслах үйлчилгээ манай улсад одоогоор байхгүй. БНСУ-ын Туршилт судалгааны хүрээлэнгийн үйл ажиллагааны жишгийг Монгол Улсад нэвтрүүлэх нь экспортыг дэмжихэд тустай.

Дүгнэлт

БНСУ-ын Засгийн газар нь экспортод чиглэсэн аж үйлдвэрлэлийг дэмжиж зорилго тавьсан өнгөрсөн зууны 60-аад оноос өнөөгийн экспортыг дэмжих тогтолцооны суурийг тавьсан. Аж үйлдвэрлэлийн хөгжлийн эхэн болон өсөлтийн шатанд төрийн үүрэг оролцоо асар өндөр байсан бол 1990-ээд оноос төрийн үүрэг оролцоог бууруулж эдийн засгийг либералчлах арга хэмжээ авсан. Төрийн манлайлал, төр хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагаа, тууштай байдал, цаг үетэйгээ нийцсэн оновчтой бодлого хөтөлбөрүүдийн үр дүнд өнөөгийн экспортыг дэмжих тогтолцоо бүрджээ.

Тус улсын өнөөгийн экспортыг дэмжих үйл ажиллагаанд гүйцэтгэх засаглалын тэргүүнээс эхлээд 18 яам, түүний харьяа агентлагууд тус тусын үүрэгтэйгээр оролцож байна. Экспортыг дэмжих үндсэн бодлогыг Төлөвлөлт, сангийн яам болон ҮХНЯ-ны төлөвлөсний дагуу Ерөнхийлөгч баталдаг. Уг бодлогын хүрээнд бусад яам агентлагуудын үүрэг оролцоо, уялдаа холбоог хангах, чиглүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, дүгнэх зэрэг ажлыг ҮХНЯ хариуцдаг. Өөрөөр хэлбэл гүйцэтгэх засаглалын түвшинд бүрэлдэн тогтсон БНСУ-ын экспортыг дэмжих тогтолцоог ҮХНЯ удирдан чиглүүлж байна. ҮХНЯ тэргүүтэй экспортыг дэмжих энэхүү тогтолцоо нь нэгдсэн удирдлагатай, нарийн зохион байгуулалттай, харилцан

уялдаатайгаар ажиллаж байна. ҮХНЯ-ны харьяа КОТРА, Худалдааны хороо зэрэг олон жилийн туршлагатай, мэргэшсэн агентлагууд нь уг тогтолцооны гол үүргийг гүйцэтгэдэг бол бусад яам агентлаг, орон нутгийн байгууллагууд экспортыг дэмжихэд өөр өөрийн чиг үүргийн хүрээнд туслах үүрэгтэйгээр оролцдог. Төрийн санхүүжилт бүхий энэхүү тогтолцоо нь үйлдвэрлэгчдийн экспорт хийхэд тулгардаг олон бэрхшээлийг хөнгөвчилж, боломжуудыг нээж өгч байна.

Манай улсын хувьд уул уурхайгаас бусад салбарын экспортыг дэмжих үр ашигтай тогтолцоо бүрдээгүй байгаа нь хариуцсан яамдын үйл ажиллагааны хөтөлбөр, зохион байгуулалтаас харагдаж байна. Яамд нь нэгдсэн бодлого төлөвлөлтгүй, уялдаа холбоо, зохион байгуулалт муу учир хэрэгжүүлэгч байгууллагууд нь үр өгөөжтэй ажиллаж чадахгүй, гаргасан төсөл хөтөлбөр, тогтоол шийдвэрүүд нь дорвитой үр дүнд хүрэхгүй байна. Энэ нь экспортыг дэмжих төрийн байгууллагын үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх шаардлага байгааг илтгэнэ. БНСУ зэрэг аж үйлдвэржсэн, өндөр хөгжилтэй орнуудын сайн туршлагаас судлан, Монгол Улсын онцлогт тохирсон экспортыг дэмжих үр ашигтай тогтолцоо бүрдүүлж байж экспорт төрөлжиж, эдийн засгийн аюулгүй байдал дээшилнэ.

Ном зүй / References:

1. [UNCTAD/DITC/TAB/2005/1](#) НУБ-ын UNCTAD байгууллагын судалгааны тайлан
2. [Forms of government support for national production and export in the Republic of Korea | Journal of International Studies \(mongoliajol.info\)](#)
3. Taejong Kim, Soogil Young “Secrets of an Economic Miracle Lessons for Sustainable Development from South Korea”, 2019
4. Jong-Dae Park, “Re-Inventing Africa’s Development: Linking Africa to the Korean Development Model”, 2019
5. Mah, Jai S., “Export Promotion and Economic Development of Korea”, Journal of World Trade, February 2006
6. [중소벤처기업부 \(mss.go.kr\)](#) БНСУ-ын ЖДҮЯ-ны цахим хуудас
7. [산업통상자원부 \(motie.go.kr\)](#) БНСУ-ын ҮХНЯ-ны цахим хуудас
8. [코트라 무역투자 24 \(kotra.or.kr\)](#) БНСУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалтын агентлагийн цахим хуудас
9. [한국무역협회-KITA.NET](#) БНСУ-ын Худалдааны хорооны цахим хуудас
10. [한국무역보험공사 \(ksure.or.kr\)](#) БНСУ-ын Худалдааны даатгалын корпорацын цахим хуудас
11. <https://www.akei.or.kr/> БНСУ-ын Үзэсгэлэн худалдааны хорооны цахим хуудас
12. [한국무역정보통신, KTNET](#) БНСУ-ын Худалдааны хорооны харьяа KTNET байгууллагын цахим хуудас
13. <https://www.ktr.or.kr/main/index.do> БНСУ-ын Туршилт судалгааны хүрээлэнгийн цахим хуудас
14. [POINT 정책정보포털 | 상세정보 \(nl.go.kr\)](#) БНСУ-ын төрийн байгууллагуудын бодлого хөтөлбөрийн мэдээллийн цахим хуудас
15. [Судалгаа \(edp.mn\)](#) Экспортыг дэмжих төвийн судалгаа
16. [PowerPoint Presentation \(mongolbank.mn\)](#) Монгол банкны судалгаа

Export Support System of the Republic of Korea and Applicable Experiences for Mongolia

Myagmar Dashdavaa

*Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia
myagmar_d@mas.ac.mn*

Abstract: *Government organizations play a pivotal role in fostering export development. We need to create efficient organizational system for economic diversification. Within this context, I examine the structure and functions of organizations headed by the Ministry of Trade, Energy, and Industry of the Republic of Korea. This ministry plans export support initiatives, which are then executed through its affiliated agencies and other governmental and nongovernmental organizations. The interconnected and well-coordinated export support system, which has evolved since the 1960s, continues to operate with notable efficiency.*

Key words: *Republic of Korea, export, industry, export support organization*

<i>The day of submission:</i>	2024.05.13
<i>Completion of review:</i>	2024.09.16
<i>Final decision for acceptance:</i>	2024.10.03

Accepted Manuscript